

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 7 дугаар сарын 22-ны өдөр

№ 21

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 08 цаг 00 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд эхлэв. Хуралдааныг аймгийн Засаг дарга С.Насанбат удирдаж, хуралд нийт 18 удирдах албан тушаалтнууд оролцохоос 13 оролцож хуралдааны ирц 55,5 хувьтай байв. Гишүүдийн ирцийн бүртгэлийг хавсаргав.

ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Хэлтэс, алба, сумдын дарга нарын өнгөрсөн 7 хоногийн ажлын тайлан, холбогдох шуурхай мэдээ, мэдээллийг танилцуулах, өмнөх шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг танилцуулах.

Хуралд оролцсон хэлтэс, албад, сумдын дарга нар өнгөрсөн 7 хоногт хийсэн ажлын тайланг танилцуулав.

ҮҮРЭГ, ДААЛГАВАР:

35,36 дугаар брак байшингийн буулгалтыг Тэргүүлэгчид дэмжсэн. Буулгалтын ажлыг анхааръя. /ОНӨГ/

“Шарилжгүй Дархан” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багууд идэвхтэй оролцох /Дархан сум/

Наадмын санхүүгийн тайланг нэгтгэж, өр төлбөрийг өгч барагдуулах /СТСХ/

Төсөл, хөтөлбөр дээр гэрээ байгуулаагүй компани байна. Гэрээ байгуулж дуусах /ХОХБТХ/

Өвөлжилтийн бэлтгэл дээр анхааръя. Бичиг нь ирсэн. /Сумд, ЗА/

Үнэлгээний шатанд яваа, зарлагдсан, зарлагдаад буцсан, ХОХБТХ дээр үлдсэн тендерүүдийн мэдээллийг нэгтгээд танилцуулах /ОНӨГ/

100 үнээний асуудлаа шахаад явмаар байна. /ХОХБТХ/

Эмнэлгийн өргөтгөлийг ХОХБТХ-тэй хамтраад эрчимжүүлэх /НБХ/

Худагны асуудлыг ХОХБТХ-тэй хамтраад эрчимжүүлэх /Орхон сум/

Хугацаатай бичиг, цохогдсон бичгүүдээ анхаарах /ХЭЗХ/

Ажлын мэдээллээ тухай бүр мэдээллэдэг байх. Хэдэн шүүх хурал, хэд нь буцсан, хэдэн нэхэмжлэх ирсэн, ямар ажил шүүх дээр байгаа гээд мэдээллүүдээ танилцуулдаг болмоор байна. /ХЭЗХ/

Ээлжийн амралтын хуваарийг танилцуулах /ТЗУХ/

2020 оны хөрөнгө оруулалтын ажлаа цэгцэлье. /ХОХБТХ/

9 дүгээр сард иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулна. Бэлтгэл хангах /ТЗУХ, ХОХБТХ/

Засаг даргын зөвлөлийн хурлыг өнөөдөр 16.00 цагт зарлаж хуралдуулах /ТЗУХ/

2019 оны 9 дүгээр сарын 2-6-ны өдрүүдэд ОХУ-ын Эрхүү мужийн Братск хотод ажиллах бизнес эрхлэгчдийг бэлтгэл хангуулах. Дарханд Үйлдвэрлэв, ХАҮТ-ыг дуудаж оролцуулах. Төлөвлөгөө гаргах. Цаашдаа Дарханд худалдааны төв нээнэ гэж ярьж байгаа. Ач холбогдол өгч ажиллах. /ХОХБТХ/

Бизнес эрхлэгчдийг Эрхүү явахтай холбогдуулан хил гаалиар бараа нэвтрүүлэх хөнгөлөлттэй нөхцөлийг судлах /ХЭЗХ/

Хөрөнгө оруулалтын ажлаа үзэж танилцуулах. /ХОХБТХ/

Санхүүжилтийн мэдээг цаасаар хэвлэж танилцуулах /СТСХ/

Хурал 09 цаг 05 минутад дуусав.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС